# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 30 өдөр Дугаар А/353 Улаанбаатар хот

## Хөрөнгө бүртгэлд тусгах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн $271^1$ дүгээр зүйлийн $271^1.1.12$ дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалт, 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 484 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2022 оны "Жагсаалт батлах тухай" 165 дугаар тушаалаар Сангийн сайдын багцад батлагдсан IX.2.1.2 хуулийн дугаартай "Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах /Улсын хэмжээнд/" төслийн хүрээнд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын IX.2.1.2.2 дахь хэсэгт заасны дагуу худалдан авсан бага оврын автобусыг Гаалийн ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын балансад хавсралтаар бүртгэсүгэй.

2. Хөрөнгийг хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд тусган, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар /Ш.Чухалбуян/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА Р.ОТГОНЖАРГАЛ

1439501 3744

Гаалийн ерөнхий газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 30-ны
өдрийн А/353 дугаар тушаалын хавсралт

**Гаалийн ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын балансад бүртгэлд тусгах тээврийн хэрэгсэлийн жагсаалт**

| № | Хөрөнгийн нэр | Арлын дугаар | Улсын дуугаар | Аш.орсон | х.нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Бүгд үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Бүртгэлд тусгах гаалийн газар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоёота Хайс Комуттер /Toyota Hiace commuter/ | JTFBNFCP306017661 | 20-23БӨН | 2022-12-30 | ш | 1 | 119,000,000.00 | 119,000,000.00 | 0.00 | 119,000,000.00 | Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар |
| | | | | | | | | **119,000,000.00** | **0.00** | **119,000,000.00** | |

01-8441.
СХОХ

# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр Дугаар 484 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гаалийн ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 1 ширхэг бага оврын автобус олж авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын дарга Ш.Чухалбуян нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

Д.Бат-Эрдэнэ

132003011

26-r huraldaan.docx

(2х)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 11 дүгээр сарын ..28...-ны өдрийн
..483... дугаар тогтоолын хавсралт

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын олж авах
автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар

| Д/д | Хөрөнгийн нэр | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Тоо ширхэг | Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг) |
|---|---|---|---|---|
| 1 | Бага оврын автобус, хөдөлгүүрийн багтаамж 3456 сс хүртэл, суудлын тоо 16 | 119,000,000.00 | 1 | 119,000,000.00 |
| | **Нийт дүн** | | **1** | 119,000,000.00 (нэг зуун арван есөн сая) |